

## УРАН ЗОХИОЛЫН ОРЧУУЛГАД ӨГҮҮЛБЭРИЙН МЭДЭЭЛЛИЙН БҮТЦИЙН ОНОЛЫН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ НЬ

Б.Удвал<sup>62</sup>

**Abstract:** *In this paper, my research was driven by the need to determine the division of thematic and rhematic elements of sentence. The main theoretical implication of my research is that the organization of the human mind influences how languages are structured. As a result logic system of sentences is similar across languages. And the logic system of thematic rhematic elements can be providing equivalence of translation. This paper also considers aspects of Chomsky's linguistic philosophy of Language universal.*

**Түлхүүр үг:** *Өгүүлбэрийн мэдээллийн бүтэц, Хэлний нийтлэг, Ноам Чомский, Түгээмэл хэл зүй, Өгүүлэгдэхүүн, Өгүүлэхүүн, онцолбор мэдээлэл, дэвсвэр мэдээлэл*

### Удиртгал

Аливаа хэлний өгүүлбэр нь юм ба түүний шинж, тэдгээрт холбогдох үйл хөдлөл гэсэн нэг үндсэн тогтолцоотой байдаг. Эдгээр нэгжүүд нь өгүүлбэрт бие даасан гишүүн болох бөгөөд үнэлэмж болон өгүүлбэрт гүйцэтгэх үүргээр нь өгүүлэгдэхүүн /subject/ өгүүлэхүүн /predicate/ байц /adverb/ тусагдахуун /object/ тодотгол /determination/ гэж ангилдаг.

Өгүүлэгдэхүүн, тусагдахуун хоёр нэр үгээр ихэвчлэн илэрч юмыг заадгаараа нийтлэг бөгөөд тодотгол, байц хоёр утгазүйн болон хэлзүйн хувьд нарийн ялгаатай ч шинжийг заадгаараа нийтлэг, харин өгүүлэхүүн нь аливаа хэлэнд үйлийг заадгаараа нийтлэг байдаг. Хүн төрөлхтний хэлнүүд хэлзүйн болон өөр бусад шинжүүдээрээ ялгаатай болох талаар хэл судлаачид олон төрлийн харьцуулсан болон зэрэгцүүлсэн судалгааг хийж дүгнэлт тайлбар өгсөн байдаг. Орчуулгад орчуулж буй хоёр хэлний хэл зүйн болон бусад ялгаатай шинжүүдийг үнэн зөв тодорхойлох нь орчуулга үнэн зөв дүйцэлтэй болоход тун чухал байдаг. Гэхдээ хэлнүүдэд адил төстэй нийтлэг зарчмууд бас байдаг. Үүнийг хэлний нийтлэг буюу /Language universal/ гэх бөгөөд орчин үед дэлхийн олон хэлнүүд ямар нэг шинжээрээ бие биенээсээ ялгарах нь гол биш харин нийтлэг зарчмуудаар адил төстэй талыг нь нээн гаргах явдал чухал хэмээн 1961 онд Нью-Йорк хотод Joseph Greenberg, Charles Osgood, James Jenkins нарын санаачилсан нэгэн эрдэм шинжилгээний хурлаар хэлний нийтлэгийн талаар баримт бичиг гаргаж хэл шинжлэл нь хэлнүүдийг тоочин бичих хэрэгсэл байснаа больж хэлний тухай бүрэн боловсорсон шинжлэх ухаан болсон хэмээн дүгнэжээ. Хэлний нийтлэгийн талаар Н.Чомский, Ж. Грийнберг нарын онол нь судалгааны чиглэлээрээ ялгаатай. Ж.Грийнбергийн онол маш олон хэлний баримт дээр тулгуурлаж авиа зүй, үг зүй

---

<sup>62</sup> Орчуулга судлаач, докторант

гэх мэт бүх түвшинд антропологи, психологийн талаас авч үздэг бол, Н.Чомскийн онолын хувьд бусад хэлийг төлөөлүүлж ганц англи хэлээр загвар болгон авч зөвхөн өгүүлбэр зүйн түвшинд философи талаас нь судалсан бөгөөд хүний бүх хэлэнд байдаг нийтлэг дүрмийн цогц болох “Universal grammar” буюу “Түгээмэл хэл зүй” хэмээх ойлголтыг тодорхойлсон. Хэлний нийтлэг хэмээх ойлголт нь хэлний дотоод мөн чанарт нэвтрэн орж юмсын учрыг тайлбарлаж чаддаг гэдгээрээ орчуулга судлалд нэн чухал ойлголт юм. Н.Чомскийн “Түгээмэл хэл зүйн” онолын хүрээнд англи монгол хэлний өгүүлбэрийн мэдээллийн бүтцэд харьцуулсан шинжилгээ хийх замаар монгол –англи уран зохиолын орчуулгад шинжилгээ хийж болох юм.

## **I. ӨГҮҮЛБЭРИЙН МЭДЭЭЛЛИЙН БҮТЦИЙН ТАЛААРХ ҮЗЭЛ БАРИМТЛАЛУУД**

### **I.1 Прагийн хэл шинжлэлийн дэгийнхний үзэл баримтлал**

Мэдээллийн бүтэц дэх онцолбор мэдээлэл болон дэвсвэр мэдээллийн талаар хэл шинжлэлд хамгийн их дэлгэрсэн томъёолол бол Прагийн хэл шинжлэлийн дэгийнхний томъёолол Халлидейн томъёолол гэсэн хоёр гол томъёолол байдаг. Аливаа хэлэнд эхийн мэдээллийн бүтэц нь өгүүлбэр доторх theme rheme –ийн /дэвсвэр онцолбор/-ын бүтэц зохион байгуулалтаар тодорхойлогддог. Хэл судлаачид үүнийг олон янзаар тайлбарласан байдаг. Тайлбар бүр ихэвчлэн тухайн судлаачийн эх хэл мөн судлаачийн хамгийн сайн мэддэг хэлэнд суурилан тайлбарласан байдаг. Дэвсвэр мэдээлэл, өгүүлбэр доторх элементүүдийн дараалал байрлалын талаарх Халлидейн тайлбар бол англи хэлний жишээн дээр хийгддэг.

Прагийн хэл шинжлэлийн дэг, Фербас нарын өгүүлбэрийн бүрэлдэхүүн хэсгүүд зөвхөн дэвсвэр-онцолбор харьцаатай байх албагүй гэсэн үзэл баримтлалыг дэвшүүлж харилцааны динамизм гэх ойлголтыг гарган ирж мэдээллийн бүтцийг байрлалаар нь хатуу тогтоож болохгүй хэмээн тайлбарладаг.

Мэдээллийн бүтэцийн энэ хоёр ангиллыг Францын сонгодог хэл, уран зохиол судлаач Хэнри Вейлл хэл шинжлэлийн судлагдахуун болгож анхны эх суурийг тавьсан гэж үздэг. Энэ ангилал дээр суурилан Прагийн хэл шинжлэлийн дэгийг үндэслэгчдийн нэг Вильям Матизиус (1928) өгүүлбэрийн бүтцийг суурь хэсэг, цөм хэсэг гэж томъёолон хос хэлбэрт хуваасныг мөн Прагийн хэл шинжлэлийн үндэслэгч Фейрбас (1964) theme, rheme гэж тус бүр өөрчлөн томъёолсон байна.

1979 онд Бабинек өгүүлбэрзүйн системийг дараах 3 түвшинд ялган ангилсан.

1. Өгүүлбэрийн утгын бүтцийн түвшин
2. Өгүүлбэрийн хэл зүйн бүтцийн түвшин
3. Өгүүлбэрийн дэс дарааллын түвшин

Эдгээрээс 3-р түвшин нь өгүүлбэрийн бүтцийн бүрдэл хэсгийг илэрхийлдэг. Үүнийг Прагийн дэгийн хэл шинжлэлд Өгүүлбэрийн Мэдээллийн Бүтэц (Эрдэнэсан. Д. 2015: 21) буюу Functional Sentence Perspective (FSP) гэж тодорхойлсон.

Өгүүлбэрийн мэдээллийн бүтцийг Хатим (1987) дараах байдлаар тайлбарласан байна.

1. Өгүүлбэрт theme буюу дэвсвэр мэдээлэл эхэнд байрлаж үүний суурин дээр rheme буюу шинэ мэдээлэл агуулсан онцолбор мэдээлэл хэлэгдэнэ.
2. Хам бичвэрээс хамааралтай (thematic) элементийн харилцаанд чухалчлагдах чанар нь хам бичвэрээс хамааралгүй (Rhematic) элементээс харьцангуй бага байдаг.
3. Хам бичвэрээс хамааралтай тематик элементүүд нь хуучин мэдээлэл агуулдаг харин хам бичвэрээс хамааралгүй рематик элементүүд нь шинэ мэдээллийг агуулдаг.

Өгүүлбэрийн хуучин мэдээлэл бүхий хам бичвэрээс хамааралтай элемент болон шинэ мэдээлэл бүхий хам бичвэрт хамааралгүй элементтэй холбоотойгоор Фербас (1964) харилцааны динамизм гэдэг ойлголтыг гаргаж ирсэн бөгөөд хам бичвэрээс хамааралтай хуучин мэдээлэл бүхий элемент нь харилцааны динамизмийн хамгийн бага зэргийг агуулдаг харин хам бичвэрээс хамааралгүй шинэ мэдээлэл бүхий элемент нь харилцааны динамизмийн хамгийн их зэргийг агуулдаг гэж үзсэн. Өөрөөр хэлбэл, дэвсвэр мэдээлэл нь харилцааны **динамизмийн** хамгийн бага зэргийг агуулдаг аж.

Харилцааны динамизм гэх ойлголт нь онолын үүднээс чухал мэт харагдаж байгаа ч theme rheme –ийг нарийвчлан тодорхойлох чадваргүй учир нь харилцааны динамизм нь өгөгдсөн мэдээлэл /шинэ мэдээлэл, хам бичвэрээс хамааралтай мэдээлэл/ хам бичвэрээс хамааралгүй мэдээлэл зэрэг элементүүдтэй холилдон өгүүлбэрт байгаа theme rheme мэдээллийн зааг ялгааг нарийвчлан тогтоож чадахгүй байна гэж зарим судлаачид үздэг. Фербасын энэ хоёрдмол бүрхэг тодорхойлолтыг нарийвчлах зорилгоор Валлаури (Vallauri 1995) өгүүлбэрт theme /дэвсвэр/ rheme /онцолбор/–ыг тодорхойлох шалгуурууд гаргаж ирснээс Wh – Question test – буюу Асуух үгээр асуулт тавих арга харьцангуй боломжит хувилбар болж байсан /Vallauri 1995/

Энэ нь “Өгүүлбэр болгон ямар нэг байдлаар асуултад хариулж байдаг. /хэн, юу, хэрхэн яаж/ гэх мэтээр. Тэгэхээр тухай өгүүлбэрийн асуултад хариулт өгч байгаа хэсэг нь онцолбор мэдээлэл болно” гээд дараах жишээгээр тайлбарлажээ. (Vallauri 1995)

Өгүүлбэр: The bikers road to the coast. Дугуйчин далайн эрэг рүү явж байна.

Асуух үгтэй асуулт: Who road to the coast? Хэн далайн эрэг рүү явж байна.

Хариулт: The bikers. Дугуйчин

Энэ өгүүлбэрт road to the coast – эрэг рүү явж байна – гэсэн хэсэг бол асуултын нэг хэсэг болж байгаа учир theme харин the bikers – дугуйчин гэдэг үг

асуултын хариу болж байгаа учир theme болно гэж тайлбарлажээ. Гэхдээ прагийн дэгийнхний нөлөө бүхий хэл шинжлэлч нар (Sgall, Danes) дан ганц асуулт тавьж өгүүлбэрийн мэдээллийн бүтцийг тодорхойлох нь учир дутагдалтай тайлбар гэдэгт санал нэг байдаг.

Мэдээллийн бүтцийн байрлал, нарийвчилсан тодорхойлолтын талаар Прагийн дэгийнхэн нэлээд судалгаа хийж дүгнэлтүүд гаргаж ирсэн боловч theme /дэвсвэр/ theme /онцолбор/-ын талаар тодорхойгүй бүрхэг зүйлүүд нэлээд байгаа юм. Гэхдээ прагийн дэгийнхэн дараах тодорхойлолтод санал нэгддэг.

Theme /Дэвсвэр/ :

- Харилцааны динамизмийн хамгийн бага зэргийг агуулдаг.
- Өгөгдсөн хуучин мэдээлэлтэй холбоотой
- Хам бичвэрийн хамааралтай
- Асуух үгтэй асуултаар шалгахад асуултын хэсэг болдог.

Rheme /Онцолбор/:

- Харилцааны динамизмийн хамгийн их зэргийг агуулдаг.
- Шинэ мэдээлэлтэй холбоотой
- Хам бичвэрээс хамааралгүй
- Асуух үгтэй асуултаар шалгахад асуултын хариу болох хэ

Прагийн хэл шинжлэлийн дэгийнхний тайлбар загвар нь нэлээд нарийн төвөгтэй бөгөөд Халидейн тайлбар загвар бол хэрэглэхэд арай энгийн хялбар гэж зарим судлаачид үздэг. (Mona Baker, 1991)

## I. II Халлидейн үзэл баримтлал

Халлидейн тайлбараар бол дэвсвэр мэдээлэл өгүүлбэрийн эхэн хэсэгт байрлах бөгөөд үүний дараа онцолбор мэдээлэл байрладаг гэжээ. Тэгэхээр Халлидейн загварт theme – theme буюу онцолбор – дэвсвэр гэсэн харьцаа холбоо үгүй юм.

Өгүүлбэрийн дотоод зохион байгуулалтыг тайлбарлах нэг арга зам нь хоёр хэсгээс тогтох өгүүлбэрийн бүтэц юм. Өгүүлбэрийн эхний хэсгийг дэвсвэр мэдээлэл гэнэ. Дэвсвэр нь хоёр үндсэн үүрэгтэй байдаг.

- Өмнөх өгүүлбэрүүдтэй холбогдож мэдээллийн уялдаа логик холбоог хангаж өгнө
- Дараагийн өгүүлбэр үйл явдлын дэвсвэр болж мэдээллийг өргөжүүлнэ.

*In Ptolemy's model provided a reasonably accurate system for predicting the positions of heavenly bodies in the sky.*

Энэ өгүүлбэрт *Ptolemy's model* - дэвсвэр мэдээлэл болж байна. Өгүүлбэр юуны тухай өгүүлэх гэж байгааг зааж байгаа учир дэвсвэр мэдээлэл болно. Өгүүлбэрийн түвшинд өгүүлэгч ярих зүйлийнхээ талаар өгч байгаа ерөнхий мэдээллийг өгүүлбэрийн эхэнд байрлуулдаг.

Өгүүлбэрийн хоёр дахь хэсгийг онцолбор мэдээлэл гэж нэрлэдэг. Энэ бол дэвсвэр мэдээллийг тодруулж өгдөг шинэ мэдээлэл. Энэ бол хам орчин уялдаа ярианы гол хэсэг юм.

Онцолбор мэдээлэл нь сонсогчид өгүүлэгчийн илгээж байгаа мэдээллийн хамгийн чухал шинэ хэсгийг агуулж байдаг болохоор өгүүлбэрийн бүтцийн хамгийн чухал хэсэг нь юм. Онцолбор мэдээлэл нь мэдэгдэлд харилцааны үүрэг гүйцэтгэдэг.

*... provided a reasonably accurate system for predicting the positions of heavenly bodies in the sky.*

Дээрх жишээ нь зохиогчийн өгч байгаа Птолмейн загварын талаар шинэ мэдээллийг агуулж байна. Үндсэндээ өгүүлбэр бүр мэдээллийн хоёр бүтэцтэй байдаг – хэлэх гэж байгаа мэдээлэл буюу дэвсвэр мэдээлэл, - тэр мэдээллийн тухай буюу онцолбор мэдээлэл гэсэн хоёр хэсэгт хуваагдана.

Мона Бейкер Халлидейн мэдээллийн бүтцийг задлах аргаар дараах цогцолборыг задалсан байна (Mona Baker, 2006:122-124)

(Степен Хокинг, Цаг хугацааны товч түүх 1988:2)

Aristotle thought that the earth was stationary and that the sun the moon the planets and the stars moved in circular orbits about the earth. He believed this because he felt, for mystical reasons, that the earth was the center of the universe, and that circular motion was the most perfect.

Анализ хийсэн байдал:

T<sub>1</sub> – Aristotle

R<sub>1</sub> { thought that:  
t<sub>2</sub> – the earth  
r<sub>2</sub> – was stationary (and that)  
t<sub>3</sub> – the sun, the moon, the planets, and the stars  
r<sub>3</sub> – moved in circular orbits about the earth.

T<sub>1</sub> – He

R<sub>1</sub> { believed this (because)  
t<sub>2</sub> – he  
R<sub>1</sub> { felt, for mystical reasons, (that)  
t<sub>3</sub> – the earth  
R<sub>1</sub> { r<sub>3</sub> – was the center of the universe, (and that )  
t<sub>4</sub> – circular motion  
r<sub>4</sub> – was the most perfect

Мона Бейкер энэ загвараас нэлээд хэдэн сонирхолтой зүйлийг тодорхойлсон.

- Мэдээллийн бүтцийн анализ нь шаталсан хэлбэртэй байж болох юм. Өгүүлбэрүүд нэгээр зогсохгүй гишүүн өгүүлбэрүүдтэй байдаг тул тэдгээр нь бүгд мэдээллийн бүтэц болдог. Гишүүн өгүүлбэр бүр өөрийн гэсэн дэвсвэр онцолбор мэдээллийн бүтэцтэй байдаг эдгээр нь магадгүй нэлээд том дэвсвэр онцолбор мэдээллийн бүтэцтэй гишүүн өгүүлбэр байж болох юм.
- Дээрх жишээнд хэд хэдэн элементийг тусгайд нь ялган хаалтад хийсэн. (because) Эдгээр элементүүд дээрх аргаар өгүүлбэрийн мэдээллийн бүтцийг задлахад тохирохгүй байна. Учир нь гэвэл эдгээр элементүүд нь эхийн дэвсвэр мэдээллийн үндсэн бүтцэд ордоггүй. Өөрөөр хэлбэл, мессеж болгон хэлэх мэдээллийн өгөгдсөн утгад нөлөөлдөггүй гэсэн үг юм. Эдгээр элементүүдийг хэл зүйд *холбоос үг* гэдэг. (however, nevertheless, because, moreover) гэх мэт. Мөн түүнчлэн өгүүлэгчийн хандлагыг илэрхийлэх *unfortunately, in my opinion, frankly, clearly* гэм мэт үгсийг хэл зүйд *ялгах үгс* гэдэг. Англи хэлний өгүүлбэрийн бүтцэд холбоос үгс болон ялгах үгс нь ихэвчлэн өгүүлбэрийн эхэнд байдаг. Өгүүлэгч өмнө нь мэдэгдэж байгаа байсан зүйлийн тухай мэдээлэхэд *холбоос үгийг*, эсвэл өгүүлэгч тухайн мэдээллийн талаар өөрийн санал бодлоо илэрхийлэхэд *ялгах үгсийг* мэдээллийнхээ өмнө байрлуулдаг. Ингэхээр *холбох* болон *ялгах* үгс нь дэвсвэрийн мөн чанартай хэдий ч /Халлидей. 1985/ мэдээллийн өгөгдсөн агуулгын нэг хэсэг болж чадахгүй тул эдгээр элементүүд нь өгүүлбэрийн бусад гол гишүүдтэй (**subject, predicator, object, complement adjunct**) адил дэвсвэр мэдээллийн бүтцэд орохгүй юм. Мэдээллийн бүтцийн анализад эдгээрийг оруулах аргууд байдаг.
- Халлидейн загварт онцолбор/дэвсвэр болон өгүүлэгдэхүүн/өгүүлэхүүний хооронд нэлээд онцгой корреляц хамаарал байгааг онцолсон байна.

Ер нь бол онцолбор дэвсвэр хоорондын ялгаа нь уламжлалт хэл зүйн өгүүлэгдэхүүн өгүүлэхүүн хоорондын ялгаа хоёр нь харьцангуй их эсвэл харьцангуй бага байдлаар ижил төстэй юм. МЭӨ 4-р зуунд Плато өгүүлбэрийн өгүүлэгдэхүүн /subject/, өгүүлэхүүн /өгүүлэхүүн/ -ийг онома, рема буюу *нэршил, хэлсэн зүйл* гэдэг нэр томъёог ашиглан хоёр ангилж байсан. Орчин цагийн онцолбор дэвсвэрийн ангилал нь Платогийн анхны ангиллаас нэг чухал шинжээрээ өөр юм. Онцолбор дэвсвэрийн ангилал бол эхэд суурилдаг учир нь салангид өгүүлбэрийн бүтэц дээр тайлбар хийдэггүй.

Өгүүлбэрийг өгүүлэгдэхүүн өгүүлэхүүнээр зааглахаас илүүтэйгээр онцолбор дэвсвэрээр зааглах мэдээллийн дарааллын хувьд ч тухайн хам сэдвийн хүрээнд тохиромжтой зүйл юм. Онцолбор дэвсвэр бол хэлзүйн ойлголт биш юм. Хэдийгээр дэвсвэр мэдээлэл ихэвчлэн мэдээллийн эхэнд онцолбор мэдээлэл төгсгөлд дэвсвэр мэдээлэл дээр тулгуурлан шинэ мэдээллийг илэрхийлэх дараалалтай байдаг ч энэ нь хэлзүйн огт холбоогүй юм.

Хэлзүйн дараалал бол хэлний хийсвэр онолын системийн нэг хэсэг юм. Мэдээллийн хам орчинд хэл зүй нь мэдээллийн уялдаа холбоо, нийцлийг бүрэн дүүрэн хангаж чаддаггүй.


### I.III Монгол эрдэмтдийн үзэл баримтлал

Монгол хэлний эхийн мэдээллийн бүтэц нь түүний утга ба хэлбэрийн бүтцийн асуудалтай нэгэн адил (Цогцолбор, үглэмж)– ийн мэдээллийн бичил бүтэцтэй холбоотой юм. Орчин цагийн монгол хэлэнд эхийн мэдээллийн бүтцийг Б.Пүрэв-Очир, Г.Жамбалсүрэн, Э.Дашдондог, З.Гулираанз, М.Базаррагчаа, А.Цог-Очир, Д.Эрдэнэсан, Ц.Баярмаа нарын эрдэмтэд монгол хэлний өгүүлбэрийн мэдээллийн бүтэц, түүний гишүүдийг илрүүлэх зарим арга хэрэглүүр, мөн монгол хэлний өгүүлбэрийн мэдээллийн бүтцийг англи хэлний өгүүлбэрийн мэдээллийн бүтэцтэй харьцуулсан судалгаа зэргийг өгүүлбэрийн түвшинд судалж дэвшүүлсэн санал, хийсэн ажлын дүгнэлт нэлээд байдаг. Эрдэмтэн А.Цог-Очир “Холбосон орчин, хам сэдэвт үндэслэн ямар нэг өгүүлбэрийн доторх онцолсон буюу утгын өргөлттэй аль нэг үг, холбоо үгээс эхлээд төгс эхийн доторх цогцолборуудыг хүртэл дэвсвэр онцолборын харьцаагаар чухалчилж онцлон ялгаж хэсэглэж болно” гэжээ. (А.Цог-Очир, 2006, № 1.36) Мэдээллийн бүтцийн хоёр гишүүнийг Э.Равдан “Суурь-тулгар”, М.Базаррагчаа, Б.Пүрэв-Очир, З.Гулираанз, Д.Эрдэнэсан нар “Дэвсвэр - Онцолбор”, Г.Жамбалсүрэн “Сэдэх мэдээлэл- Шинэ мэдээлэл” гэж нэрлэсэн байдаг. (З.Гулираанз, 1993: 75)

Эх судлалд түүний бүрдүүлбэрүүдийн эхний үглэмжийг суурь үглэмж (Констатирующее высказывание) гэх бөгөөд суурь үглэмж нь хойших үглэмжүүдийнхээ мэдээллийн бүтцийг нөхцөлдүүлэх бөгөөд үглэмж бүрийн онцолбор гишүүн дараах үглэмжийнхээ дэвсвэр гишүүн болох замаар хоорондоо холбогдож “Эх”-ийн мэдээллийг бүтцийг цогцлуулдаг гэж томъёолсон байна. Харилцааны үүргийн талаасаа “Онцолбор гишүүн нь мэдээллийн бүтцийн цөм бол дэвсвэр гишүүн нь “Эх”-ийн бүрдүүлбэрүүдийн мэдээллийн бүтцийг зангидаж байдаг чухал хэрэглүүр” гээд эх судлалын ном зохиолд дор дурдсан 3 хэв маяг утга зохиолын хэлний найруулгын олон хэв маягт харьцангуй түгээмэл тохиолддог гэснийг онцолжээ. (З.Гулираанз.1993.76-77)

1. Шугаман цуваа бүтэц О – Д – О – Д ....

2. Цацраг маягийн бүтэц



3. “Үүсмэл” дэвсвэр гишүүнтэй цуваа бүтэц Д<sub>1</sub> – О<sub>1</sub> Д<sub>2</sub> – О<sub>2</sub> Д<sub>3</sub> – О<sub>3</sub>

Мөн эрдэмтэн М.Базаррагчаа мэдээллийн бүтцийг бүрдүүлэгч дэвсвэр онцолборыг хэлэхүйн үзэгдэлд хамааруулан авч үзэхдээ хэлний нэгжийн талаас онцолсон ба дэвсвэр гишүүн нь хэлний ба хэлний бус орчноос шалтгаалан өөр хоорондоо сэлгэж байдаг. Онцолбор гишүүн нь өмнөх өгүүлбэрээ бодвол шинэ

мэдээ агуулах боловч төдхөн хуучин мэдээ болжээ. Бусад гишүүдээс нэг нь шинэ мэдээ бүхий онцолсон гишүүн болно. Энэ онцолсон гишүүн нь дараагийн шинэ мэдээнд түрэгдэн хуучин мэдээ бүхий гишүүн болно. Иймд хэлний талаас өгүүлбэрийн бүтэц нь тогтвортой, хэлэхийн талаас тогтворгүй байдаг гэж тайлбарлажээ. Эрдэмтэн Б.Пүрэв-очир, З.Гулираанз (1993.66-67) нар монгол хэлний ерөнхийлөн хамаатуулахын ай нь зөвхөн хэл зүйн төдийгүй мэдээллийн бүтцийг тодорхойлдог өвөрмөц ай болох талаар сонирхолтой санаа дэвшүүлж хэлний баримтын жишээ болгож “Тунгалаг Тамир” зохиолын нэг хэсэгт эхийн бүтцийн задаргааг орос орчуулгатай нь харьцуулан хийгээд монгол хэлний энэхүү өвөрмөц хэлбэр нь “Эх”ийн утга мэдээллийн бүтэцтэй нарийн учир холбогдолтой байна. Өөрөөр хэлбэл монгол хэлний эзэнд хамаатуулах нөхцөлүүд субъектийг илэрхийлэх өвөрмөц хэрэглүүр, онцолбор гишүүнийг “Эх”-ийн түвшинд илэрхийлэх онцлог арга гэж үзэх үндэстэй байна гэж дүгнэжээ.

1. Олноо өргөгдсөний дөтгөөр оны зуны эхэн сарын нэгэн өдөр Их Тамирын хойгуур гарсан замаар гуч орчим насны хар хүн<sup>1</sup> нилээд ачаатай морин тэрэг хөтлөөд явж байв.
2. (☉)Нар салхинд гандаж, хир хөлсөнд нэвтэрч урагдсан дээл~~ээ~~ мөн өнгийн юмаар нөхсөн болохоор ямар эдээр хийсэн нь мэдэгдэх аргагүй ажээ.
3. (☉) Ханхар дөрвөлжин мөрөнд~~өө~~ утаа болсон цахиур буу хөндлөн үүрч, (☉) даахирсан бүдүүн хар гээг~~ээ~~ дарайсан хөх ямбуу алчуураар шуужээ.
4. (☉)Шороонд буурал болсон өтгөн хар хөмсгөн доорх том гэгчийн дүрлэгэр **нүд нь** удаан удаан цавчивч,
5. (☉) хөлс дааварласан хүрэн **нүүрэнд нь** урт замын алжаал илэрч, гүн бодолд автагдан хүрлийхийг харвал ядарсан болон уурласан болох нь мэдэгдэмгүй ажээ<sup>01</sup>.

1. В первых числах первой летней луны четвертого года царствования богдогэгэна по дороге вдоль северного берега Тамира двигалась одноконная телега. Коня за повод вел статный монгол лет тридцати.
2. Одет **он** был в грязный, пропахший потом, выгоревший от ветра и солнца, залатанный разноцветными заплатами терлик.
3. За широкой спиной **у него** висело старинное кремневое ружье.
4. Свалявшаяся черная коса была подвернута и стянута на затылке синим бязевым платком.
5. **Его** густые брови и припухшие веки были запорошены пылью, большие выпуклые глаза блестели как-то мрачно, смуглое утомленное лицо казалось хмурым.
6. Трудно было разгадать, отчего **он** хмурился: то ли от усталости, то ли от раздражения.
7. Время от времени **мужчина** оборачивался и глядел на дорогу, иногда он останавливался и поправлял груз.






### II.1 Орчуулгад хийсэн өгүүлбэрийн мэдээллийн бүтцийн шинжилгээ

Эхийн мэдээллийн бүтцийн онолын судалгааг орчуулгын баримт дээр тулгуурлан судлахдаа орчуулгазүй болон орчуулгад тохирох хамгийн тохиромжтой тодорхойлолтыг тогтоохоос илүү эх материал болон орчуулгын мэдээллийн дэвсвэр, онцолбор мэдээллийн зааг ялгааг нь зөв тогтоож харьцааг нь хадгалан орчуулах боломжийг нь судлах зорилгоор нэг ерөнхий дэвсвэр гишүүнээр зангидагдсан олон онцолбор гишүүн бүхий цацраг маягийн бүтэц бүхий нэг цогцолборыг сонгон авч орчуулгын хувилбартай нь харьцуулан судалгаа хийлээ.

Монгол хэлний энгийн хүүрнэх өгүүлбэрт онцолбор мэдээлэл нь ямагт дэвсвэрийн дараа байрладаг бөгөөд дэвсвэр нь өгүүлбэрт өгүүлэгдэж буй юм, онцолбор нь дэвсвэрийн тухай өгүүлж буй хэсэг гэж ихэнх судлаачид үздэг.

**Жав гуай**<sup>д1</sup> өнгөрсөн хаврын цагаан хагднаар хадан гэртээ харина гэж бодож байсан боловч бүтсэнгүй<sup>о1</sup>. “Би ер нь долоон голтой амьтан юмаа” гэж хүнд ярина.<sup>о2</sup> “Үхэхийн тухай бодож яваагүй боловч үхэхээс нэг их айхгүй хүн<sup>о3</sup> байж. Үүнийгээ ойлгохдоо санаа амарсан бөгөөд элдэв зовлон гаслан болж гиншигнэлгүй зоригтой тайвнаар үхлээ хүлээж байна.<sup>о4</sup>

ӨМБ-ийн цацраг маягийн бүтэц (З.Гулираанз, 1993: 76)



Эх бичвэрийн энэ цогцолбор нь 4 үглэмжээс бүтсэн бөгөөд сэдэв нь “Жав өвгөн, ирж буцах ертөнцийн жамыг ойлгосон хүн”. Суурь үглэмж нь “Жав өвгөн хадан гэртээ харина гэж бодож байсан” 2 болон 3-р үглэмжийн дэвсвэр мэдээлэл хоосноор илэрсэн 4-р үглэмжийн дэвсвэр нь ерөнхийлөн хамаатуулах нөхцөл

бүхий заах үг, үйлийн хамаатуулах нөхцөл бүхий үйл үгээр илэрч онцолбор мэдээллийг хамаатуулах нөхцөлөөр ерөнхий дэвсвэрт зангидсан байна.

Монгол хэлэнд хамаатуулахын ай нь зөвхөн хэлзүйн төдийгүй мэдээллийн бүтцийг тодорхойлдог учир холбогдолтой өвөрмөц ай юм. (З.Гулираанз, 1993: 66)

**Англи орчуулга:**

**Jav guai** had been, *during the fall of the previous spring's withered grass*, thinking to return to the earth, but in vain. “It seems like I have seven lives,” **he** would say to people. Never, in the back of his mind, had he really thought about death, but **he** seemed not be afraid of it. Understanding this brought him relief, and **he** calmly awaited his end with no moaning in grief.

Халлидейн загвар (М.Бейкер, 2006: 122)

Th<sub>1</sub> – Jav guai

R <sub>1</sub>	{	Had been:
		th <sub>2</sub> – <i>during the fall of the previous spring's withered grass</i> , (thinking)
		rh <sub>2</sub> – to return to the earth (but)
		rh <sub>3</sub> – in vain

Th<sub>1</sub> – He

Rh <sub>1</sub>	{	Say to people
		th <sub>2</sub> – it seems like
		rh <sub>2</sub> – I have seven lives
		{
th <sub>3</sub> – he really thought		
rh <sub>3</sub> – about death, (but )		
th <sub>4</sub> – he		
		rh <sub>4</sub> – seemed not be afraid of it


Th<sub>1</sub> – understanding this /he/

Rh <sub>1</sub>	{	th <sub>2</sub> - Brought him
		rh <sub>2</sub> – relief (and)
		th <sub>3</sub> – calmly awaited
		{
th <sub>4</sub> –		
rh <sub>4</sub> – no moaning in grief		

Мэдээллийн бүтэц нь шаталсан хэлбэртэй байна. Гишүүн өгүүлбэрүүд нь бүгд мэдээллийн бүтэц болсон бөгөөд бүгд өөрийн гэсэн дэвсвэр онцолбор мэдээллийн бүтэцтэй байгаа нь монгол хэлний ӨМБ-тэй ойролцоо байна.

Дээрх жишээнд хэд хэдэн элементийг тусгайд нь ялган хаалтад хийсэн. (but, and, with) Учир нь гэвэл, эдгээр элементүүд нь эхийн дэвсвэр мэдээллийн үндсэн бүтцэд ордоггүй өөрөөр хэлбэл мессеж болгон хэлэх мэдээллийн өгөгдсөн утгад нөлөөлдөггүй гэсэн үг юм. Эдгээр элементүүдийг хэл зүйд *холбоос үг* гэдэг. (however, nevertheless, because, moreover,) гэх мэт. Ингэхээр *холбох* болон *ялгах* үгс нь дэвсвэрийн мөн чанартай хэдий ч /Халлидей. 1985/ мэдээллийн өгөгдсөн агуулгын нэг хэсэг болж чадахгүй тул эдгээр элементүүд нь өгүүлбэрийн бусад гол гишүүдтэй (**subject, predicator, object, complement adjunct**) адил дэвсвэр мэдээллийн бүтцэд орохгүй юм. Харин англи хэлний үндсэн чанар бүхий туслах үйл үгс болох be, have нь төгс цагийн хэрэглээнд гол үйл үгтэй /main verb/ хамт хэрэглэгдэж байж утга илэрхийлдэг. Англи орчуулгад thinking гэдэг үгийг хугацаа заасан байцын ард салган оруулсан нь ӨМБ-ийг загварчлахад холбоос үгийн адил үүрэгтэй болох магадлалтай байна. Халлидейн тодорхойлсноор англи хэлэнд байр заасан болон хугацаа заасан байцаар дэвсвэр мэдээлэл илрэх боломжтой ч төгс цагийн туслах үйл үг болон гол үйл үгийн дундуур таслан орох нь мэдээллийн бүтцийн тохиромжтой дараалал биш юм. Мөн 3-р өгүүлбэрт had he really thought about death гэсэн дараалал ч мөн адил юм.

ӨМБ-ийн цацраг маягийн бүтэц (З.Гулираанз, 1993: 76)



Англи орчуулгыг монгол хэлний цацраг маягийн бүтцээр загварчилж үзэхэд дээрх загвар гарч ирж байна. Энэ нь монгол мэдээллийн бүтцийн дарааллын хувьд монгол эхтэй нэлээд төстэй болсон байгаа нь харагдаж байна.

### Дүгнэлт

Монгол англи хэл нь хэдийгээр төрөл бус хэлнүүд боловч мэдээллийн бүтцийн шаталсан хэлбэр болон өгүүлбэрийн мэдээллийн дарааллын хувьд хувьд нийтлэг байх магадлалтай байна. Монгол хэлний өгүүлбэр энгийн хүүрнэх хэлбэрт хэл зүйн бүтцийн хувьд SOV гэсэн дараалалтай харин англи хэл SVO гэсэн дараалалтай байдаг. Хоёр хэлний subject буюу өгүүлэгдэхүүн өгүүлбэрийн эхэнд орж байгаа нь Халлидейн өгүүлбэрийн мэдээллийн бүтэц “theme rheme” гэсэн дараалалтай байна гэдэг тодорхойлолтод тохирсон нийтлэг шинжтэй байна. Мөн англи хэлний гишүүн өгүүлбэр бүр өөрийн гэсэн дэвсвэр онцолбор мэдээллийн бүтэцтэй байдаг эдгээр нь магадгүй нэлээд том дэвсвэр онцолбор мэдээллийн бүтэцтэй гишүүн өгүүлбэр байж болох юм гэсэн Халлидейн таамаг монгол хэлний ӨМБ-д бас байж болох талтай юм. Монгол хэлний ерөнхийлөн хамаатуулах, биед хамаатуулах, үйлийн хамаатуулах нөхцөлүүд нь өгүүлбэрийн

мэдээлэл дамжуулах талаас эзнийг ялган онцлох тал дээр өвөрмөц бас нэлээд түгээмэл байдаг бол англи хэлэнд биеийн төлөөний үг эзнийг ялган онцлох хэрэглээ нь өвөрмөц бас нэлээд түгээмэл байна. (Орчуулгад энэ нь бие биенээ орлох боломжтой). Нийлэг бүтэц бүхий монгол хэлэнд утгын харьцаанд орж буй нэр үгс нь үйл үгэндээ захирагдах дараалалтай тул монгол хэлний цөм хэмжигдэхүүн нь (head last) буюу хойноо байдаг энэ хэмжигдэхүүний дүрэм зөрчигдөхгүй. Англи хэлний хувьд утгын харьцаанд орж буй гишүүд мөн үйл үгэндээ захирагдаж цөм хэмжигдэхүүн нь (head first) буюу урдаа байдаг. Хэлний цөм хэмжигдэхүүний хамаарлыг ӨМБ –ийг тодорхойлоход ашиглаж болох бөгөөд энэ нь орчуулгын дүйцлийг хангасан эсэх бас орчуулгын найруулгад шинжилгээ хийхэд чухал ач холбогдолтой байж болох юм.

### Ном зүй

1. Аюурзана.Г Өлзийтөгс.Л (2005), Монголын сонгомол өгүүллэгүүд, УБ., Гүн паблишн
2. Гулираанз. З Пүрэв-Очир. Б (1993) Монгол хэлний өгүүлбэр зүйн онол, УБ., УБИС
3. Пүрэв-Очир.Б (2007), Монгол хэлний бүтэц, утга, үүрэг, хэрэглээ, Уб., МУБИС
4. Оюунцэцэг.Ж (1993), Англи хэлний зүй, Уб., Урлах эрдэм
5. Эрдэнэсан. Д (2015), Монгол хэлний эхийн онол судалгаа, УБ., Адмон Принт
6. Оуун-Undraa. N, (2009) “The Old bird”. Mongol Survey № 22
7. Mona Baker. (2006) In other words a course book on translation, London, Taylor and Francis group
8. Burlaga, Christine Marie, "A contrastive approach to the thematic analysis of text and genre: An examination of lead news articles in Le Monde, Al-Ittihad, and The New York Times" (2004). Theses Digitization Project. 2578. <http://scholarworks.lib.csusb.edu/etd-project/2578>